



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/201

Булган


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 29.1.5, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Эрчим хүчний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Харилцаа, холбооны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга, хот байгуулалтын Сайд болон аймгийн Засаг даргын хооронд байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний дөрөвдүгээр хавсралтын 6-д заагдсан Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн мэдээлэл бүрдүүлэх, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдөл бүрдүүлэх хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг бүрдүүлэх, үйл ажиллагаа, зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хэрэгжилтийг хугацаанд нь хангуулж, тайлан, төлөвлөгөөг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Д.Буманбаяр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З. БАТЗОРИГ

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дугаар сарын 11-ны өдрийн 1/2019 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ
БҮРДҮҮЛЭХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ АЖЛЫН ХЭСГИЙН
БҮРЭЛДЭХҮҮН

- Ажлын хэсгийн дарга: - Д.Буманбаяр /Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга/
- Гишүүд: - Б.Батболд /Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга/
- А.Гантөмөр /Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга/
- М.Мөнхбат /Статистикийн хэлтсийн дарга/
- О.Ихбаяр /Аймгийн Ерөнхий архитектор/
- Б.Ганзориг /Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга/
- Г.Отгонбаяр /"ЭБЦТС" ТӨХК-ийн ахлах инженер/
- Ч.Оюун /"МХС" ТӨХК-ийн Булган салбарын дарга/
- Г.Энхтайван /"Булган Мээж" ХХК-ийн Ус хангамж ариутгах татуургын инженер/
- Г.Баярсайхан /"Булган Мээж" ХХК-ийн Ерөнхий инженер/
- Э.Мөнх-Эрдэнэ /"Булган АЗЗА" ТӨХК-ийн Ерөнхий инженер/
- Н.Баасанжаргал /Тохижилт үйлчилгээний ангийн дарга/
- Нарийн бичгийн дарга: - Г.Батцагаан / Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн/

Аймгийн Засаг даргын 2019 оны 01 дугаар сарын 11-ны өдрийн 16001 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ХОТ БАЙГУУЛАЛТЫН КАДАСТРЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ӨГӨГДӨЛ БҮРДҮҮЛЭХ ХУВААРЬ

Д/д	Дэд сангийн нэр	Маягтын дугаар	Хариуцах байгууллага	Хугацаа
1	Нийгмийн дэд бүтэц	НДБ-1	Статистикийн хэлтэс	2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор
2	Барилга байгууламж	ББ-1, ББ-2, ББ-3, ББ-4	ГХБХБГ	2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн дотор
3	Тохжилт, ногоон байгууламж	ТНБ	ГХБХБГ	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
4	Ус хангамж	УХ	Тохжилт, үйлчилгээний анги "Булган Мээж" ХХК УХАТ	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
5	Ариутгах татуурга	АТ	"Булган Мээж" ХХК УХАТ	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
6	Дулаан хангамж	ДХ	"Булган Мээж" ХХК Дулааны алба	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
7	Цахилгаан хангамж	ЦХ	"ЭБЦТС" ТӨХК Булган салбар	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
8	Зам, тээвэр	ЗТ	"Булган АЗЗА" ТӨХК	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор
9	Харилцаа холбоо	ХХ	"МХС" ТӨХК-ийн Булган салбар	2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор